

БИЗНЕС ГЭЖ ЮУ ВЭ?

Хүрэх үр дүн

- Бизнесийн талаарх мэдлэгээ өргөтгөх.
- Бизнесийн төрөл, бизнесийн орчинд нөлөөлөх гадаад ба дотоод хүчин зүйлсийг мэдэх.
- Бизнесийн шинэ санаа олох түүнийгээ хэрэгжүүлэхийг эрмэлзэх.

Агуулгын хувьд

Бизнес судлал хичээл нь маш чухал судлагдахуйнтай хичээл бөгөөд хамрах хүрээ нь хүний өдөр тутмын хэрэгцээ болон үйл ажиллагаатай холбоотой байдаг. Хүн бизнесийн үйл ажиллагааны талаар сонин хэвлэлээс уншиж сонсдог. Тэгвэл бизнесийн үйл ажиллагааг бүдүүвчээр харуулбал:



Бизнесийн үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө аж ахуй эрхлэгч нь чухам ямар төрлийн бизнес эрхлэгч болохоо сонгоно. Бизнесийн төрөл бүр улс орны эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй байдаг. Одоо бүгдээрээ бизнесийн төрөлтэй танилцацгаая:

1. Өөртөө ажлын байр бий болгогч

Энэ бол аж ахуйн үйл ажиллагаагаа өөрөө хийж бас ашгаа өөртөө авдаг хүн юм. Ийм төрлийн хүмүүс бол гэр бүлийн дэлгүүр эрхлэгч, засварчид, тооцооны нягтлангаас эхлээд эмч, хуульчид ч байж болно.

Энэ төрлийн аж ахуй эрхлэгчид өөр хүнийг ажилд авдаггүй тул өөрсдөө ажлын бүтэн өдөр ажилладаг.

2. Цаг үеийн боломжийг мэдэрдэг аж ахуй

Боломжийг бүрэн ашиглах үүднээс ажилчдыг шинээр авч маш хурдан хугацаанд аж ахуйгаа байгуулж мөн боломжийн хурдаар

- эрхлэгч:** ажилладаг хүн. Ихэнх тохиолдолд шинээр авч буй ажилчид нь үүсгэн байгуулагчийн өөрт нь байхгүй тийм ур чадварыг эзэмшсэн хүмүүс байдаг.
- 3. Зохион бүтээгч:** Зохион бүтээх онцгой ур чадвартай, хамгийн сайн чанарын бараа бүтээгдэхүүний талаар бодож чаддаг, дараа нь үүнийг үйлдвэрлэх, худалдаалах аж ахуйн байгууллагыг байгуулдаг хүн юм. Өндөр технологи нь компаний хөгжлийн шинэ чиг хандлагыг тодорхойлдог.
- 4. Бусдыг хуулагч, давтагч:** Бусдын гаргасан загвар, санааг хуулж өөрийн аж ахуйгаа байгуулагчид, Франчайз болон ижил төрлийн жижиглэнгийн худалдаа бол ийм аж ахуйн тод жишээ юм.
- 5. Ажил хэргийн өсөлтөөс хэмнэлт гаргагчид:** Хөнгөлөлттэй үнэ, маш бага шууд бус зардлын тусламжтайгаар иж борлуулалт хийж түүнээсээ хожоо гаргадаг хүмүүс.
- 6. Өөрийн болгогчид:** Бусдын бий болгосон бизнесийг авч түүнийгээ дахин худалддаг хүмүүс. Бусдын бизнесийг авч түүнийгээ “булаан авах” нь санхүүгийн хямралд орсон байгууллагуудад их тохиолддог. Удирдлагын шинэ соргог санаанууд тухайн бизнесийг аварч болох юм.
- 7. Худалдан авах худалдах мэргэжилтэн**
- 8. Дамлан худалдаалагчид:** Энэ нь компани үйл ажиллагааг сайжруулахаар худалдаж аваад дараа нь ашигтайгаар худалдаж чаддаг хүмүүс. Барааг худалдаж аваад илүү үнээр зарж борлуулдаг хүмүүс. Үл хөдлөх хөрөнгө, урлагийн бүтээл, эртний эдлэл, үр тариа зэрэг нь ийм төрлийн худалдааны тод жишээ юм. Зах зээлийн эдийн засгийн ойлголтод энэ нь сөрөг утга агуулдаггүй.
- 9. Байгууллага доторх бие даасан бизнес:** Байгууллагын эрхэлж байгаа бизнесийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд шинэ санааг нэвтрүүлж туршдаг хүмүүс юм. Хэдийгээр энэ хүмүүс үүнээс ашиг хүртдэггүй ч байгууллагадаа санхүүгийн эрсдэл авч ирдэггүй. Тэд байгууллагын удирдлагын арга туршлагыг үүнд ашигладаг.
- 10. Франчайз:** Франчайз гэдэг нь зах зээлд олны танил болсон тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломж, борлуулах эрхийг эзэмшигч хүнтэй гэрээ байгуулсанаар бизнесийн үйл ажиллагаа явуулах үйл ажиллагаа юм. Франчайз эзэмшигч нь тухайн бизнесийг эзэмших бөгөөд бүтээгдэхүүний нэр, эзэмшигчээ байгуулсан гэрээний хүрээнд ажиллана.
- 11. Амьдралын шаардлагаар аж ахуй эрхлэгч:** Амьдрахын тулд гутал тослогч, жижиг худалдаа хийх зэрэг үйлчилгээг өөрийн бизнес болгосон ажилгүй хүмүүсийг үүнд багтааж ойлгоно.

Арга зүй, хичээлийн зохион байгуулалт

Бизнес гэж юу вэ? сэдвийн онцлог нь хичээлийг танхимын бус хүрээнд зохион байгуулах, судалгаа авах боломжтойгоороо давуу талтай. Жишээ нь сум орон нутаг, дүүрэгтээ бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байгаа жижиг дунд бизнес эрхлэгчтэй уулзаж бизнесийн санаагаа анх хэрхэн олсон, хэрхэн өргөжүүлсэн талаар мэдээлэл авч зурагжуулан сургуулийнхаа бүтээлийн самбарт сурталчилж болох юм. Энэ үйл ажиллагааны үр дүнд танай сургуулийн сурагчдын дундаас дараагийн бизнесмен төрөх эхлэлийг тавьж болох юм.

Орон нутагдаа хэрэгцээтэй байгаа бизнесийг судалж гаргаж ирэх боломжтой. Үүндээ тулгуурлан бизнес нь тасралтгүй үргэлжлэх, өргөжих ёстой гэдгийг ухаарч бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээг бид хэрэглэн амьдарч байгаа тухай бодит жишээгээр тайлбарлаарай.

Танхимын хичээлээр сурагчид бизнесийн хичнээн төрлийг мэдэж байгаа талаар судалгаа авч үр дүнг нь танилцуулж болно. Судалгаа авсны дараа доорх мэдээллийг сурагчдад танилцуулаарай, өмнө нь сонсож байгаагүй бизнес байхыг ч үгүйсгэхгүй юм.

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БИЗНЕС

1. Хүнсний үйлдвэр
2. Тамхины үйлдвэр
3. Сүлжмэл эдлэлийн үйлдвэр
4. Оёмол болон бэлэн бүтээгдэхүүний үйлдвэр
5. Модон эдлэлийн үйлдвэр
6. Тавилгын үйлдвэр
7. Цаас, цаасан бүтээгдэхүүний үйлдвэр
8. Хэвлэлийн үйлдвэр
9. Хими, химийн бүтээгдэхүүний үйлдвэр
10. Нефть, нефтийн бүтээгдэхүүн үйлдвэр
11. Резин болон хуванцар эдлэлийн үйлдвэр
12. Арьс ширний үйлдвэр
13. Чулуу, шаавар, шил, цутгамал эдлэлийн үйлдвэр
14. Металлург боловсруулах үйлдвэр
15. Металл хийцийн үйлдвэр (Машин ба тээврийн хэрэгсэл)
16. Тоног төхөөрөмжийн үйлдвэр (Цахилгаан тоног төхөөрөмжөөс бусад)
17. Цахилгаан тоног төхөөрөмжийн үйлдвэр
18. Тээврийн тоног төхөөрөмжийн үйлдвэр
19. Хэмжих болон хянах хэрэгслийн үйлдвэр (Фото зураг, эмнэлэг, нүдний шил, цагны тоног төхөөрөмж)
20. Бусад төрлийн үйлдвэр

БӨӨНИЙ ХУДАЛДАА

21. Бөөний худалдаа (хадгалалт даах бараа)
22. Бөөний худалдаа (хадгалалтын нөхцөл шаардах бараа)

ЖИЖИГЛЭНГИЙН ХУДАЛДАА

23. Барилга, сантехник, цэцэрлэгжүүлэлтийн материал нийлүүлэлт
24. Төрөл бүрийн барааны дэлгүүр
25. Хүнсний барааны дэлгүүр
26. Автомат борлуулагч, шатахуун түгээх цэг
27. Эмэгтэй бэлэн хувцасны болон гоёл чимэглэлийн дэлгүүр
28. Албан талсалгаа, гэрийн тавилга, бусад тавилгын дэлгүүр
29. Нийтийн хоолны цэг
30. Бусад төрлийн жижиглэн худалдаа

ҮЙЛЧИЛГЭЭ

31. Зочид буудал, халамжийн төв, бусад түр амрах болон амьдрах байрны үйлчилгээ
32. Авто машин засварын болон гараашийн үйлчилгээ
33. Нэрлэсэн үйлчилгээ
34. Чөлөөт цагийг өнгөрүүлэх төв
35. Бизнесийн үйлчилгээ
36. Төрөл бүрийн засварын үйлчилгээ
37. Кино үзвэр
38. Эрүүл мэндийн үйлчилгээ
39. Хуулийн зөвлөлгөө өгөх үйлчилгээ
40. Боловсролын үйлчилгээ
41. Нийгмийн үйлчилгээ
42. Гишүүнчлэлтэй (клуб, холбоо) байгууллагын үйлчилгээ
43. Музей, уран зургийн галерей, ургамал болон амьтаны хүрээлэн
44. Төрөл бүрийн бусад үйлчилгээ
45. Бонд, валют арилжааны төв
46. Брокерын үйлчилгээ

47. Гоо сайхны үйлчилгээ
48. Компьютер, оффисын үйлчилгээ
49. Мэдээлэл технологийн үйлчилгээ
50. Аюулгүй байдлыг хангах үйлчилгээ
51. Бялдаржуулах үйлчилгээ
52. Хэвлэлийн үйлчилгээ
53. Шуудан, бараа хүргэх үйлчилгээ
54. Байгууллагын захиалгаар арга хэмжээ зохион байгуулах үйлчилгээ
55. Өвөрмөц үйлчилгээ
56. Дасгалжуулах үйлчилгээ (шалгалт, хөгжим г.м)

Мэдээллийг харуулсны дараа танай орон нутагт хэрэгцээтэй байгаа бизнесийг судалж гаргаж ирэх даалгавар өгөөрэй. Үүндээ тулгуурлан бизнес нь тасралтгүй үргэлжлэх, өргөжих ёстой гэдгийг ухаарч бизнес эрхлэгчидийн үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээг бид хэрэглэн амьдарч байгаа тухай бодит жишээгээр тайлбарлаарай.

Бизнес эрхлэгч нь шудрага, найдвартай, ёс төртэй чанараараа бусдад танигдвал бизнес бат суурьтай хөгждөг талаар хэлэлцүүлэг хийх, нутгийн иргэдээс танигдсан хүнийг сурталчлах аян зохион байгуулж болно.

“Бизнес гэж юу вэ?”, “Яагаад бизнес хийх гэж” сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлэн бизнес бол зайлшгүй, бизнес хийх боломж нээлттэй гэсэн нэгдсэн дүгнэлтэд хүрэхэд багш анхаарна. Сэдвийн судлах хүрээнд “Нийгмийг бизнес эрхлэгчид авч явдаг” сэдвээр илтгэлийн уралдаан зохион байгуулж болно. Эсвэл багш урьдчилан сэдвээ өгөөд хичээлийн цагаа богино хэмжээний илтгэл тавиулж болно. Сэдвийн хүрээнд илтгэл тавихдаа, Бизнес ашиг чухал ч бизнесийн хариуцлагаа, ухамсар түүнээс ч чухал гэдгийг сурагчид гаргаж ирэхэд багш анхаараарай. Мөн нийгэмд ээлтэй, ногоон эдийн засгийг дэмжсэн бизнес эрхлэх илүү ирээдүйтэй гэдгийг сурагчид гаргаж ирэх нь чухал.

Сэдвийн төгсгөлд дараах ойлголтуудыг холбох даалгаврыг гүйцэтгүүлж сурагчдын мэдлэгийг цэгцлээрэй.

1. бий болгож хүмүүсийг орлогоор хангадаг
 2. татвар төлдөг
 3. Улс орны эдийн засгийн хөгжилд тус болох татан төвлөрүүлдэг
 4. Нийгмийн амьжиргааны чанарыг
 5. үеэ бэлддэг
 6. Үнэ цэнийг бий болгож эдийн засгийн дэмждэг
 7. Өрөлдөөний бий болгож бүтээгдэхүүний болгодог
 8. Бизнес эрхлэгчиддээ бий болгож өгдөг
 9. Судлаач бүтээгдэхүүн хөгжүүлэгчдийг бий болгоход түлхэц болж өгдөг
 10. Бизнесийн эздэд сорилт бий болгож мөн түүнтэй хамт ирэх шагналыг
 11. хилийн чандаас оруулж ирж улс орны дутууг нөхдөг
 12. хэрэглэж хөгжлийг дэмждэг
- A. Шинэ техник технологи
 - B. Ажлын байр
 - C. Үнийг бага
 - D. орлого
 - E. бий болгож өгдөг
 - F. Улсад
 - G. Сайжруулдаг.
 - H. шинэ бараа, үйлчилгээ
 - I. өсөлтийг
 - J. хөрөнгө оруулалт
 - K. Хойч
 - L. Бараа бүтээгдэхүүн

Уншиж судлах ном гарын авлага

Цахим мэдээллийн сан Банкуудын холбооны цахим хуудас
 Санхүүгийн байгууллагуудын танилцуулга
 Бизнес ба нийгэм 73-96 хуудас

Үнэлгээний хувьд

Бизнес гэж юу вэ? сэдвийн хүрээнд сурагчдыг үнэлэхдээ хэлэлцүүлэгт оролцож өөрийн үзэл бодлоо илэрхийлж буй байдал, оролцоог үнэлэх, илтгэл бичиж оролцсон илтгэл нь судалгаатай үндэслэлтэй эсэхийг үнэлж болно. Орон нутгийнхаа жижиг дунд бизнес эрхлэгчтэй ярилцаж, зурагжуулж, сурталчлах үйл ажиллагааны оролцоогоор үнэлж болно.

Даалгавар ба шалгуурын уялдаа холбоо

	Үзүүлэлт	№	Бизнесийн талаарх мэдлэгээ өргөтгөх.	Бизнесийн төрөл, бизнесийн орчинд нөлөөлөх гадаад ба дотоод хүчин зүйлсийг мэдэх.	Бизнесийн шинэ санаа олох түүнийгээ хэрэгжүүлэхийг эрмэлзэх.
1	Даалгавар	1	√		
		2	√		
		3	√		√
		4	√		√
		5	√		√
		6	√		√
2	Сорил	1	√		
		2	√		
		3	√		√
		4	√		√
		5			√
3	Холбох даалгавар	1	√		√

ДААЛГАВРЫН ХАРИУ, ГҮЙЦЭТГЭЛ

Даалгавар 1-ийг сурагчдаар гүйцэтгүүлэн оруулах

Даалгавар2.

Багшид зөвлөмж: Бизнес байхгүй бол амьдрал байхгүй гэдгийг ойлгох. Ингэснээрээ бизнес бол зайлгшүй гэдгийг ойлгуулах. Бизнес явагдснаар дэлхий, улс, үндэстэн, улс орон, хүмүүс оршин тогтнож, амьдардаг гэдгийг ойлгуулах. Бизнес хандах хандлагыг үүгээр ойлгуулж өгнө. Бизнес хийж байгаа хүмүүсийг үнэлэх үнэлгээ өөрчлөгдөх ёстой. Амжилттай явагдаж байгаа бизнес, түүнийг амжилттай хөтөлж, удирдаж яваа хүмүүсээр бахархах хэрэгтэй. “Муусайн баячууд” биш “Биднийг тэжээгчид” гэдэг хандлагыг төлөвшүүлэх ёстой.

Бизнес бол ашгийн төлөө явагддаг гэдгийг ойлгуулахад анхаарах хэрэгтэй. Бизнес хийж байгаа аав, ээж, ах, эгч, хамаатан садан, танидаг хүнийхээ бизнесийг дэмжих нэг хэлбэр бол тэдэнд төлбөр төлөх гэдгийг ойлгуулах.

“Г” даалгаврыг гүйцэтгэхдээ “үндэсний статистийн” мэдээллийг ашиглах хэрэгтэй бөгөөд багш өөрөө энэ мэдээллийг өгч болох ба хүүхдүүдэд интернэтээс олох даалгавар өгч болно. Зөвхөн Монголын мэдээлэл биш гэдгийг анхаарна уу. Дэлхийн хэмжээнд жижиг дунд бизнес, нийт бизнесийн ихэнх хувийг эзэлдэг гэдгийг мэдснээр жижиг дунд бизнест хандах хандлага төлөвших ёстой.

Монголд нийт 78 0000 гаруй аж ахуйн нэгж байдгаас 90 хувь нь жижиг дунд бизнес байдаг.

Жижиг Дунд Үйлдвэр гэвэл үйлдвэрлэл эрхлэгчийг хамруулан үзэх ба үйлчилгээ, худалдаа гэх мэт салбарын бизнес хамаарагдахгүй. ЖДБ (жижиг дунд бизнес) гэвэл бүх салбарт бизнес эрхлэгчид хамаарагдана.

Жижиг Дунд Бизнесийн борлуулалтын орлого, үндсэн хөрөнгө, ажилчдын тоог үндэслэн ангилна. ЖДҮ-ийн тухай хуулинд зааснаар Монгол улсад ЖДБ-ийг дараах байдлаар ангилдаг.

Хүснэгт Жижиг дунд бизнесийн ангилал

	Үйлдвэрлэл			Үйлчилгээ			Худалдаа		
	БО	ҮХ	АЖ	БО	ҮХ	АЖ	БО	ҮХ	АЖ
Бичил	>20 сая	>50 сая	5<	>20 сая	>50 сая	5<	>20 сая	>50 сая	5<
Жижиг	20-100 сая	50-200 сая	6-20	20-100 сая	50-200 сая	6-10	20-150 сая	50-200 сая	6-10
Дунд	100-500 сая	200 сая - 1 тб	21-100	100-500 сая	200 сая - 1 тб	Nov-50	150 сая - 1.5 тб	200 сая - 1 тб	11-100

Хүснэгт Европын холбооны улсуудын Жижиг дунд бизнесийн ангилал

Категори	Ажилчдын тоо	Орлого	Тайлан балансын нийлбэр
Дунд	<250	≤ € 50 m	≤ € 43 m
Жижиг	<50	≤ € 10 m	≤ € 10 m
Бичил	<10	≤ € 2 m	≤ € 2 m

Египет

Египетийн дийлэнх бизнес нь жижиг, дунд, бичил бизнес байдаг. 97% нь 10 ба түүнээс доош ажлын байртай байдаг. Дунд хэмжээний бизнес эрхлэгчдийн 2.7 % нь 10< >50 ажлын байртай байдаг. Нутгийн хэмжээнд нийт дунд бизнес эрхлэгчдийн 0,4 % нь 50-аас дээш хүмүүсийг ажлын байраар хангаж байдаг.

Кени

Ажилчдын тоогоор Бичил = 10 хүртэл
Жижиг = 10 аас 50 хүртэл
Дунд = 150 аас 1000 хүртэл

Энэтхэг

Бичил бизнес эрхлэгчдийн тоног төхөрөмж 2 500 000 rupees илүү байх
Жижиг бизнес эрхлэгчдийн тоног төхөрөмж 2 500 000 rupees их ба 50 000000 rupees хэтрэхгүй
Дунд бизнес эрхлэгчдийн тоног төхөрөмж 50 000 000 rupees их ба 100 000 000 rupees хэтрэхгүй

Их Британ

Жижиг дунд бизнес эрхлэгчид гэдэг категорт хамрагдахийн тулд дараах үзүүлэлттэй байх хэрэгтэй. Үүнд.
Эргэлтийн хөрөнгө нь £25m аас бага
250 аас доош ажилчинтай
Хөрөнгийн хэмжээ нь £12.5m бага

Канад

Жижиг бизнес эрхлэгчид 100 ажилтантай гэж тодорхойлдог
Дунд бизнес эрхлэгчид 100-500 ажилтантай гэж тодорхойлдог

Даалгавар 3.

Багшид зөвлөмж: Бизнес хийхэд хүргэх өөр олон шалгаан байдаг. үүнийг илүүлэхийг зорих хэрэгтэй. Тухайлбал хүн дуртай ажлаараа бизнес хийх, чаддаг ажлаараа бизнес хийх, байнга мөнгөөр гачигддаг гэх мэт.

Даалгавар 4.

Багшид зөвлөмж: Бизнесийг үйлдвэрлэлийн ба үйлчилгээний гэж ангилдаг. Сангийн сайдын 2011 оны 4 дүгээр сарын 29 –ний өдрийн 103 тоот тушаалын 1 дүгээр хавсралт **ЭДИЙН ЗАСГИЙН БҮХ ТӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРЫН АНГИЛАЛ**-ыг баталсан. Энэхүү ангилалын дэлгэрэнгүйг www.legalinfo.mn сайтаас харах ба сурагчдад гэртээ ажиллах даалгавар хэлбэрээр тус сайтыг судлаж болно. Сурагчид даалгаварыг гэрт хийснээр дээрх веб сайттай танилцаж, бүх төрлийн хуулийг эндээс авч болохыг мэдэж авахаас гадна өөрийн дотны хүмүүсийн болон таньж мэддэг хүмүүсийн эрхэлж байгаа бизнесийн төрлүүдийн эдийн засгийн хамаарагдах салбарыг нарийн мэдэж авах боломжтой.

ЭДИЙН ЗАСГИЙН БҮХ ТӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРЫН АНГИЛАЛ

Монгол Улсын эдийн засгийн салбарын ангилал нь олон улсын жишгээр хийгдсэн болно. Эдийн засгийн 21 салбар, 99 дэд салбар, 990 бүлэг, 9900 анги, 95 дэд ангид ангилагддаг.

	Салбар	Дэд салбар	Бүлэг	Анги	Дэд анги
	A	01	011	0111	0144.1
A	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, засаг барилт, ан агнуур	Газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл болон түүнд холбогдох туслах үйл ажиллагаа	Нэг наст ургамал	Үр тариа (цагаан будааг оруулахгүйгээр), буурцагт болон тосны ургамал тариалалт	Хонь өсгөх үйл ажиллагаа
B	Уул уурхай, олборлолт	Чулуун нүүрс			
C	Боловсруулах үйлдвэр				
D	Цахилгаан, хий, уур агааржуулалт				
E	УС ХАНГАМЖ; БОХИР УС ЗАЙЛУУЛАХ СИСТЕМ, ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ БОЛОН ЦЭВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА				
F	Барилга				
G	БӨӨНИЙ БОЛОН ЖИЖИГЛЭН ХУДАЛДАА; МАШИН, МОТОЦИКЛИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ				
H	ТЭЭВЭР БА АГУУЛАХЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА				
I	ЗОЧИД БУУДАЛ, БАЙР, СУУЦ БОЛОН НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭ				
J	МЭДЭЭЛЭЛ, ХОЛБОО				
K	САНХҮҮГИЙН БОЛОН ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА				
L	ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА				
M	МЭРГЭЖЛИЙН, ШИНЖЛЭХ УХААН БОЛОН ТЕХНИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА				
N	УДИРДЛАГЫН БОЛОН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА				

O	ТӨРИЙН УДИРДЛАГА БА БАТЛАН ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, АЛБАН ЖУРМЫН НИЙГМИЙН ХАМГААЛАЛ				
P	БОЛОВСРОЛ				
Q	ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНД БА НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА				
R	УРЛАГ, ҮЗВЭР, ТОГЛООМ НААДАМ				
S	ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА				
T	ХҮН ХӨЛСЛӨН АЖИЛЛУУЛДАГ ӨРХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА; ӨРХИЙН ӨӨРИЙН ХЭРЭГЛЭЭНД ЗОРИУЛАН ҮЙЛДВЭРЛЭСЭН НЭР ТӨРЛӨӨР НЬ САЛГАЖ ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖГҮЙ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ				
U	ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА, СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА				

Эх сурвалж: www.Legalinfo.mn эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем

Даалгавар 5.

Багшид зөвлөмж:

1. Хар цай буцалгаж бэлтгэж тавина
2. Тогоогоо (саваа) халаана.
3. Сүүлний өөх хийж болно. Мөн хуурна.
4. Тос хийж халаана.
5. Цайнд будаа хийвэл будаагаа хийж хуурна.
6. Бэлтгэж тавьсан хар цайгаа хийж буцалгана
7. Сүүгээ хийж цайгаа болгоно.

Жич: эхний алхамыг орхигдуулан будаатай цай хийж байсан тохиолдол гарч байсан. Ийм үед будаатай цай чанах боломж байхгүй.

Даалгавар 6.

Багшид зөвлөмж:

1. Бизнес хийх шинжлэх ухааныг мэддэг байх
2. Хоолны технологийн мэдлэгтэй байх
3. Эрхлэх бизнесийн үйл ажиллагааны дагуу хүмүүс ажлуулах
4. Бизнес хийж хуримтлуулсан ашгаасаа үнэт цаасны зах дээрээс хувьцаа худалдан авах

БАТАТГАЛ

СОРИЛЫН ХАРИУ

1. Хэрэглэгчийн хүслийг хангах зориулалтаар бараа, үйлчилгээг үйлдвэрлэж борлуулах үйл ажиллагаа юм.
2. Г

5.Багшид зөвлөмж

- Хөрөнгийн удирдлага - байгууллагын хязгаарлагдмал нөөцийг бизнесийн зорилгод хүрэхийн тулд зөв зохистой удирдах
- Хүний нөөцийн удирдлага
- Бараа ажил үйлчилгээ бэлтгэн нийлүүлэлт

- Санхүүгийн болон үйлдвэрлэлийн төлөвлөлт
- Борлуулалтын буюу орлого ашиг ажиллагааны төлөвлөлт
- Бүтээгдэхүүний удирдлага - тоо болон чанарын удирдлага
- Маркетинг гэх мэт.